



73

ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар A/143

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2023 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, шинэчлэх /үргэлжлэх/” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ч.Энхжаргал

(Шивээ Овоо хувьцаат компанийн хүний нөөцийн албаны дарга)

Х.Нацагням

(Шивээ Овоо хувьцаат компанийн

технологи дамжлагын хэсгийн  
инженер)

Хөндлөнгийн төлөөлөл:  
Ш.Буяннэмэх

(Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:  
Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг  
төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа  
хариуцсан мэргэжилтэн)

2. “Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын  
талбай байгуулах, шинэчлэх /үргэлжлэх/” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах  
ажлыг хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг  
үнэлгээний хорооны дарга (Б.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

